



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Замын-Үүд дэх Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 227,403,780.66 (хоёр зуун хорин долоон сая дөрвөн зуун гурван мянга долоон зуун наян төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 76,513,526.08 (далан зургаан сая таван зуун арван гурван мянга таван зуун хорин зургаан төгрөг найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хилийн цэргийн 0108 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Замын-Үүд дэх Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Цэенрэгзэн, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа В.Намхайнямбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн
 328 дугаар тогтоолын хавсралт



**ЗАМЫН-ҮҮД ДЭХ ГААЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХИЛИЙН ЦЭРГИЙН 0108 ДУГААР АНГИД БАЛАНСААС
 БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Дэлгэц-зорчигчийн үйлчилгээний заалны мэдээллийн,	2022-12-30	ш	3,545,960.00	9	31,913,640.00	19,281,157.50	12,632,482.50
2	Камер/гадна хяналтын 59ш/-3Т	2023-01-17	ш	1,308,495.66	46	60,190,800.36	23,407,533.51	36,783,266.85
3	IP камер/гаазанд суурилсан 38ш/ АТ	2023-11-03	ш	4,405,094.80	20	88,101,896.00	22,025,474.00	66,076,422.00
4	IP камер/хананд суурилсан 10ш/ АТ	2023-11-03	ш	4,719,744.43	10	47,197,444.30	11,799,361.07	35,398,083.23
						227,403,780.66	76,513,526.08	150,890,254.58
						(хоёр зуун хорин долоон сая дөрвөн зуун гурван мянга долоон зуун наян төгрөг жаран зургаан мөнгө)	(далан зургаан сая таван зуун арван гурван мянга таван зуун хорин зургаан төгрөг найман мөнгө)	(нэг тавин сая найман зуун ерэн мянга хоёр зуун тавин дөрвөн төгрөг тавин найман мөнгө)
Нийт дүн								